

Захиргааны зөвлөлийн 2020 оны 05 сарын 07-ны  
өдрийн хурлаар хэлэлцэж батлав.



## **БАРИЛГЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ** **/2020-2021 оны хичээлийн жил/**

### Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 15-р зүйл, Хөдөлмөрийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн А/187 тоот тушаалаар баталсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам”-ыг баримтлан тус коллежид суралцагч элсүүлэн суралцуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Үлгэрчилсэн журмын дагуу элсэлтийн журмыг жил бүр шинэчлэн боловсруулж, захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулна.
- 1.3. Суралцагч элсүүлэх ажлын гол зорилго нь Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн элсэгчдийн сурах чадвар, мэдлэгийн түвшин, авьяас, төлөвшлийг бодитойгоор үнэлж, цаашид мэргэжлийн ажил хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхол, мэдлэг чадвартай хүмүүсийг сонгон элсүүлэхэд оршино.

### Хоёр. Элсэгчдэд тавих шаардлага

- 2.1. Техникийн боловсрол олгох сургалтанд элсэгчид нь бүрэн дунд болон мэргэжлийн боловсролтой байх.
- 2.2. Мэргэжлийн боловсрол олгох сургалтанд элсэгчид нь суурь боловсролтой байх.
- 2.3. Мэргэжлийн боловсрол олгох нэг жилийн сургалтанд элсэгч нь насанд хүрсэн байх.

### Гурав. Элсэлтийн зохион байгуулалт

- 3.1. Элсэлтийг захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас баталсан элсэлтийн хяналтын тоог баримтлан элсэлтийг зохион байгуулна. Ажлын хэсэг нь шаардлагатай албан тушаалтнуудыг оролцуулж, элсэлт зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллана.
- 3.2. Ажлын хэсгийн үйл ажиллагаа:
  - а. Элсэлтийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилна.
  - б. Элсэгчдийг онлайнаар бүртгэж, шалгаруулалтыг ил тод, шударга зохион байгуулна.
  - в. Элсэгчдийг сонгосон мэргэжлийн ангид нь элсүүлнэ.
  - г. Элсэлттэй холбогдсон санал, гомдлыг цаг тухайд нь барагдуулна.

### Дөрөв. Элсэгчдийн сонгон шалгаруулалт

- 4.1. Мэргэжлийн боловсрол олгох сургалтанд элсэгчдийг суурь боловсролын гэрчилгээний түвшингийн үнэлгээний дунджаар нь жагсааж элсүүлнэ.
- 4.2. Техникийн боловсрол олгох сургалтанд элсэгчдийг бүрэн дунд боловсролын гэрчилгээний түвшингийн үнэлгээний дунджаар нь жагсааж элсүүлнэ.
- 4.3. Мэргэжлийн боловсрол олгох нэг жилийн сургалтанд элсэгчдийг бүртгүүлсэн дарааллаар нь хяналтын тоонд багтааж элсүүлнэ.

### Тав. Хөнгөлөлттэй нөхцлөөр элсүүлэх

#### **5.1 Мэргэжлийн боловсрол олгох сургалтанд элсэгчид:**

5.1.1 9-р ангийг “А” үнэлгээтэй төгсөгчийг онооны дараалал харгалзахгүй мэргэжил сонгуулж элсүүлнэ.

5.1.2 Улсын олимпиадад 1-3 дугаар байр эзэлсэн элсэгчийг онооны дараалал харгалзахгүй мэргэжил сонгуулж элсүүлнэ.

#### **5.2 Техникийн боловсрол олгох сургалтанд элсэгчид:**

5.2.1 Аймаг, хот, дүүргийн олимпиад, мэргэжлийн ур чадварын уралдаанд оролцож, 1-3 дугаар байр эзэлсэн элсэгчийг онооны дараалал харгалзахгүй мэргэжил сонгуулж элсүүлнэ.

5.2.2 Мэргэжлийн боловсрол олгох сургалтаас элсэгчид нь сургуулийн олимпиад, уралдаан тэмцээнд 1-3 дугаар байр эзэлсэн, “А” үнэлгээтэй суралцсан бол онооны дараалал харгалзахгүй мэргэжил сонгуулж элсүүлнэ.

5.2.3 Дээрх хөнгөлөлттэй нөхцлийг нэмэлт бүртгэлийн хугацаанд тооцохгүй.

### Зургаа.Элсэлтийн бүртгэл

6.1. Элсэлтийн онлайн бүртгэл 2020 оны V/04- VII/03-ны хооронд сургуулийн вэб хуудсаар / [www.cc.edu.mn/burtgel](http://www.cc.edu.mn/burtgel) / явагдана. Шаардлагатай тохиолдолд нэмэлт бүртгэлийг 8 сард зохион байгуулна.

6.2. Онлайн бүртгэлд бүртгүүлсэн иргэн элсэлтийн хураамжийг төлснөөр бүртгэл баталгаажина. /ХААН банк, 5041076656 тоот данс, эзэмшигчийн нэр Ч. Живзүнпагма, бүртгэлийн хураамж 20000 төг/ Бүртгэлээ баталгаажуулаагүй тохиолдолд тус бүртгэлийг хүчингүйд тооцно.

6.3. Бүртгэл нь баталгаажсан иргэн 2020 оны VI/29- VII/03-ны хооронд өөрийн биеэр, эсвэл итгэмжит хүнээр дамжуулан дараах бичиг баримтыг сургууль дээр авчирч, элсэлтийн ажилтанд хураалгана.

а. Боловсролын үнэмлэх /эх хувиар/

б. Хувийн хэрэг /эх хувиар/

в. Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээны хуулбар

г. Хөнгөлөлттэй элсэх нөхцөлд шаардагдах нотлох баримт

6.4. Элсэгчид хяналтын тоонд хүрээгүй тохиолдолд нэмэлт элсэлтийг зохион байгуулна.

6.4.1. Нэмэлт элсэлтийн онлайн бүртгэл 2020 оны VII/03- VIII/22-ныг хүртэл явагдана.

6.4.2. Бүртгэл нь баталгаажсан иргэн 2020 оны VIII/10-VIII/21-ны хооронд өөрийн биеэр, эсвэл итгэмжит хүнээр дамжуулан дараах бичиг баримтыг сургууль дээр авчирч, элсэлтийн ажилтанд хураалгана.

6.5. Бүртгүүлэгчийн тэнцсэн эсэхийг 2020 оны 7 дугаар сарын 6-ны өдөр, 8 дугаар сарын 24-ны өдөр вэб хуудсаар дамжуулан мэдээлнэ.

### Долоо.Бусад

7.1. Элсэлтийн үед бүрдүүлэх материалыг хуурамчаар бүрдүүлсэн, материал дутуугаас үүсэх хариуцлагыг бүртгүүлэгч хариуцна.

7.2. Бүртгэлийн хураамжийг ажлын хэсгийн даргын зөвшөөрлөөр сургууль, мэргэжил сурталчлах, элсэлтийн үйл ажиллагаанд шаардагдах бичгийн хэрэгсэл, програм хангамж, суралцах эрхийн бичиг авах болон хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаа зэрэгт зарцуулж, тайлагнана.

7.3. Суралцагч элсүүлэхдээ энэхүү журмын 6.2-т зааснаас бусад хураамж авахыг хориглоно.

7.4. Элсэлтийн явцын мэдээ, суралцах эрхийн бичиг олгосон тайланг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь хүргүүлнэ.